

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг  
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2019.02.13

№ 02.

### Ногдол ашгийн тухай

“Компанийн тухай” хуулийн 46, 47, 64 дүгээр зүйлийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөг, нийт 1 888 104 000 /Нэг тэрбум найман зуун наян найман сая нэг зуун дөрвөн мянга/ төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд заасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлсугай.
3. Ногдол ашгийг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн байранд мөнгөн хэлбэрээр олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнах болон Компанийн тухай хуулийн 46.14 дүгээр зүйлд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Д.Дуламсүрэнд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ